



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

“Корэкс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
бүрэлдэхүүнд орох өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Корэкс” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орох өөрчлөлтийг хавсралтад заасны дагуу бүртгэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 5 өдрийн дотор ирүүлэхийг “Корэкс” ХХК (М.Золжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



1518000024